

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии



РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

V

Международная конференция
при поддержке Президента Монголии



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И.В.Кульганек
доктор (Ph.D) Н.Хишигт
кандидат филол. наук Д.А.Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г. Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун
Эмхтгэгч-редактор: Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology



RUSSIAN ACADEMY OF
SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

V

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar
2023

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Edited and compiled by

acad. S.Chuluun
D.Sc.(Philology) I.V.Kulganek,
Ph.D (History) N.Khishigt,
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

Cultural heritage of the Mongolis: manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И.Ф.Поповой	11
Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ	13
Приветствие генерального секретаря международной ассоциации монголоведов, академика С.Чулууна	15
Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн мэндчилгээ	
Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын мэндчилгээ	

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх.

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

Э. Баярчимэг

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

К. И. Бикмаева

Национальные программы по монгольской письменности (монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных документов в области языковой политики монголии

Л. Ганбат

Ибн Арабшах-ийн “Acāibu’l makdūr” зохиолд нүүдэлчдийн байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

Л. С. Дампилова

Жанровое разнообразие архивных материалов Монгольской экспедиции 1967 года

И. М. Захарова, М. В. Мандрик

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

И. В. Кульганек, Н. В. Захарова

Фотографии о монголии и монголах в Институте восточных рукописей РАН

Э. Мөнхцэцэг

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж толь бичгийн тухай

Б. Нацагдорж, О. Оюунжаргал

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

Д. А. Носов

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

Р. Ю. Почекаев

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

Э. Пүрэвжав

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

Т. Д. Скрынникова

Сакральность правителя и его ритуальные функции
(По материалам анонимной Altan tobci)

М. В. Федорова

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из
экспедиции в Северную Монголию (1910 г.)

А. Д. Цендина

Гадания на кубиках (по материалам квартиры-музея
Ц.Дамдинсурэна и коллекции Р.Отгонбаатара)

Б.-Х. Б. Цыбикова

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

С. Чулуун, Н. Хатанбаатар

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в
Монгольском гоби

Т. И. Юсупова

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

DOI10.48612/IVRRAN/bzva-13r4-mfp2

Б.Нацагдорж
О.Оюунжаргал

**“ХҮРЭЭНИЙ ХЭРГИЙН ЗҮЙ (庫倫事宜)”
ХЭМЭЭХ СУРВАЛЖИЙН ТУХАЙ**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь XVII зуунд анх Жавзандамба хутагтын Хүрээ хэмээн сууриа тавьжээ. Манж Чин улсын ноёрхлын үед Халхын зүүн хоёр аймаг, Жавзандамба хутагтын шавийн захиргаа болон Оростой харилцах хэргийг хариуцсан сайдыг Манжийн талаас томилон суулгах болсон тул Хүрээ нь говийн арын Монголын чухал зангилаа газрын нэг болсон байна. Манж Чин улсын үеийн Хүрээний сайдын газрын албан үүрэг, эрх хэмжээг судлахад архивын анхдагч эх сурвалжууд хангалттай боловч тухайлан Хүрээний сайдын газрын эрх үүргийг тодорхойлон бичсэн зохиол одоог хүртэл мэдэгдээгүй байсан юм. Иймээс манж болон хятад хэлээр хавсарган бичсэн Хүрээний хэргийн зүй (庫倫事宜) хэмээх сурвалж Япон улсад хадгалагдаж буйг судлан шинжилж үзсэн үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үг: Хүрээний хэргийн зүй, 庫倫事宜, Хүрээний сайдын газар, сайд ван Юндэндорж.

B.Natsagdorj,
O.Oyunjargal

ON THE SOURCE CALLED KU-LUN SHI-YI 庫倫事宜

Ulaanbaatar, the capital city of Mongolia, was first founded in the 17th century as the Khuree of Jebzundamba Qutuγtu. During the rule of the Manchu Qing Dynasty, Khuree became one of the important administrative hubs of Mongolia on the north side of the Gobi, since the Manchus established here the office of Governor of Khuree to administer two eastern Aimag of Khalkh and the Great Disciple of the Jebzundamba Qutuγtu and the relations with Russia. Although, we have sufficient primary archival sources to study the duties and responsibilities of the Governor of Khuree during the Manchu Qing period, until recently we did not have the written sources specifically dedicated to the office of the Khuree Governor. Therefore, we present the results of the research and analysis of the source called 庫倫事宜, written in Manchu and Chinese, kept in Japan.

Keywords: the Affairs of Khuree, 庫倫事宜, Governor's Office of Khuree, Governor and Prince Yundendorji.

Сурвалжийн тухай

Энэхүү “Хүрээний хэргийн зүй (kulun shiyi, 庫倫事宜)” хэмээх хятад нэр бүхий манж, хятад хэлээр хавсарсан сурвалж нь эдүгээ Япон улсын Осака их сургуулийн харьяа номын сангийн Гадаад судлалын их сургуулийн ховор номын хөмрөгт (бүртгэлийн дугаар 90000109604, захиалгын дугаар Q210.390) хадгалагдаж байна. Үүнд, юуны өмнө тус сурвалжийн тухай мэдээллийг анх өгсөн Япон улсын Соока их сургуулийн профессор Мүраками Нобү-аки, хэвлэх болон хуулбарлах зөвшөөрлийг найр тавин өгсөн тус номын сан, мөнхүү зөвшөөрлийг авахад туслалцаа үзүүлсэн Осака олон улсын их сургуулийн хүндэт профессор Мацүда Коичи, Осака их сургуулийн профессор Мацүи Дай нарт гүн талархал илэрхийлье.

Тус сурвалж нь дорно дахины уламжлалт дэвтэр хэлбэртэй товхисон 24.9Ч13.1cm хэмжээтэй, тогтуун хичээнгүй тигээр бэхээр бичсэн 115 хуудас бүхий бөгөөд нүүр хавтсанд дээр дурдсан номын сангийн бүртгэлийн дугаарыг наасан бөгөөд дотор талд сурвалжийн нэрийг 庫倫事宜 (Хүрээний хэргийн зүй) хэмээн ханз үсгээр зүүн дээд буланд улаан өнгийн цаасан дээр тусгайлан бичиж наажээ. Манж хэлний бичвэрийг нэг нүүрт 8 мөрөөр бичсэн бол хятад хэлний бичвэр нь нэг нүүрт 9 мөр байна. Манж хэлний бичвэр нь 3-р хуудаснаас эхэлж, 104-р хуудсанд дуусч байна. Үүнээс хойш тус зохиолын хятад бичвэрийг хавсарган үдсэн байх бөгөөд уг эх нь хятад номын толгой эхэлдэг зуршил ёсоор 114-р хуудаснаас эхэлж, 106-р хуудсанд хүрээд дуусч байна. Уг хоёр эхийг тус тусад нь зохион бичээд нийлүүлэн нэгэн дэвтэр болгож үджээ.



Манж эхийн эхний хуудасны баруун гар талын цулгай хэсэгт, дугуй хүрээнд тойруулан 大阪外国語學校 図書課 буюу Осака Гадаад хэлний сургууль, Номын сангийн салбар, голд нь 大正15.3.26 буюу Тайшоогийн 15 оны 3 сарын 26 хэмээх огноо болон 10960 хэмээх дугаар бүхий тамга, түүний доор улаан хүрээ бүхий дээр дурдсан бүртгэлийн дугаар бүхий дардас даржээ. Эндээс үзвэл, тус сурвалж анх Осакагийн Гадаад хэлний сургууль, хожмын Осакагийн Гадаад хэлний их сургуулийн¹ номын санд Тайшоогийн 15 буюу 1926 онд бүртгэгдсэн аж.

Тус сургуулийн номын сангийн бүртгэлд, уг сурвалжийг, “зохиогч тодорхойгүй, зохиогдсон оныг Төр гэрэлтийн гутгаар он” хэмээгээд, сурвалжийн нэрийг манжаар оноож, катакана үсгээр, “へセイ、タクラハ、クルン、デ、テフヒ、バイタ、イチヒヤラ” буюу *hesei takūraha kurun de tehuhi baita icihiyara* хэмээн тэмдэглэсэн агаад монголчилбол, “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэх” болно. Үргэлжлүүлэн, “Сурвалжийн уг нэрийг орчуулбал, Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэх” утгатай, өөрөөр хэлбэл сурвалжийн агуулга нь Зарлигаар зарсан тамга бүхий Хүрээний хэрэг шийтгэгч сайдын түшмэлийн тогтолцоо бөгөөд цалин хөлс, түшмэл, морь унаа зэргийг дэлгэрэнгүй дурдсан” хэмээн тодорхойлсон нь тус сургуулийн манж хэлний багш Ватанабэ Шигэтароо (*watanabe shigetarō*, 渡部薰太郎) болно [Watanabe 1932, 29-30].

1861 онд Япон улсын Нара мужид төрсөн Шигэтароо Ватанабэ англи хэл сурч, харилцаа холбооны ажилтан, хуурай замын цэргийн орчуулагчаар ажиллаж байгаад 1908 онд тухай үед Японы мэдэлд байсан Манжуур, Солонгосын хойгийн зааг Гандо² нутагт очиж, 1924 он хүртэл ажиллаж амьдрахдаа нутгийн манж хүмүүсээс манж хэл сурч, улмаар 1925-1936 он хүртэл буюу нас барах хүртлээ Осакагийн гадаад хэлний сургуульд манж хэл заажээ. 1922 онд байгуулагдсан Осакагийн гадаад хэлний сургуулийн анх 9 гадаад хэл үзэж байсны нэг нь монгол хэл болно. Тус сургуулийн оюутнууд үндсэн болон хавсарга хоёр хэл үзэж байснаас, монгол хэлний ангийн хавсарга хэл нь манж хэл байв [Jin Tingshi 2017, 61-83]. Тийнхүү Шигэтароо Ватанабэ бээр манж хэл заахын сацуу манж хэлний сурах бичиг, хэлний зүй, манж номын

¹ Осакагийн Гадаад хэлний их сургууль нь 2007 онд Осакагийн их сургуультай нэгдэж, тус сургуулийн Гадаад судлалын сургууль болжээ.

² Тус нутагт түрэн орсон солонгосуудын өгсөн нэр Гандо (間島), түүний япон дуудлага Кантоо. Өнөөгийн БНХАУ-ын Жилин мужийн Яньбянь солонгос угсаатны өөртөө засах жөү.

бүртгэл, Алтан улсын судар дахь нэрийн тайлбар, зүрчин үсгийн судалгаа хийж хэвлүүлжээ [Uehara 1966, 1967]. Өөрөөр хэлбэл, XX зууны эхээр манж нарын уугуул нутагт одож, 48 насандаа манж хэл сурч, улмаар 10 гаруй жил Осакагийн гадаад хэлний сургуульд манж хэл заасан Ш.Ватанабэгийн цуглуулсан буюу бүртгэсэн манж номын дотор тус “Хүрээний хэргийн зүй” хэмээх сурвалж байжээ. Харамсалтай нь чухам хаана хэнд байсан тус сурвалж хэзээ, хэрхэн түүний гарт хүрсэн нь тодорхойгүй байна.

Сурвалжийн зохиогч, зохиогдсон он цаг

Сурвалжид зохиогч хийгээд уг зохиолыг бичиж дуусгасан он цагийг тодорхой дурдаагүй боловч ойролцоогоор тодорхойлж болох хэдэн сэжүүр буй. Үүнд, манж хэлний бичвэр нь Сайшаалтай ерөөлтийн 25-р (1820) оны 11 сарын 11 хэмээн дуусч байгаа боловч уг эхийн дотор Төр гэрэлтийн 3-р (1823) он хүртэл тэмдэглэсэн дансыг Хүрээний сайдын яаманд хадгалж буй тухай дурдсанаас үзвэл, юу ч гэсэн уг зохиолыг 1823 оноос хойш зохиожээ. Гэхдээ 1827 оноос өмнө болов уу. Үүний учир нь уг сурвалжийн зохиогч лугаа холбогдоно.



Хүрээний сайд, ван Юндэндорж

(Mongoleireise zur späten Goethezeit: Berichte und Bilder von der russischen
Gesandtschaftsreise 1805/06


(=Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland, suppl. vol. XIII), 1971.)

Зохиогчийн тухайд, манж бичвэрт, “*Сайшаалтай ерөөлтийн арван хоёрдугаар (1807) онд Зарлигаар зарсан Хүрээнд сууж тэргүүлэн хэрэг шийтгэгч сайд, шадарт явах халхын засаг төрийн жүн ван, төрийн эфү миний хошууны эр цээлсэн данс*” хэмээгээд, Халхын Түшээт хан аймгийн нэгэн засаг хошууны хүн амын дансыг оруулсан нь Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд, төрийн жүн ван, төрийн эфү Юндэндоржийн хошууны данс байна. Тиймээс уг сурвалжийг зохиогч нь, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдаар тасралгүй 44 жил ажилласан халхын засаг, төрийн жүн ван төрийн эфү Юндэндорж болно.

Тэрбээр 1765 онд Халхын Түшээт хан аймгийн Дундад баруун этгээдийн хошууны засгийн төрийн жүн ван бөгөөд анх Хүрээнд сууж хэрэг шийтгэсэн сайд, төрийн эфү Санжайдоржийн монгол хатнаас төржээ. Эцэг Санжайдоржийг 1778 онд нас барахад, 13 настай (хий насаар) байсан Юндэндоржийг, эхийн хамт Хүрээнээс Бээжин хотноо шилжүүлэн суулгаж, түүнээс хойш дотор ордонд өсөж хүмүүжжээ. Юндэндоржийн эхийн тухайд тодорхой мэдээ үгүй авч, *wu* хэмээх дуудлагатай ханз үсгээр тэмдэглэсэн буюу ү-у авиагаар эхэлсэн овогтой, ойр төрөл нь Хүрээний хамба номун хан Жамбалдорж, хамба Шагдар хэмээх ах дүү хоёр аж [Wulanbagen 2016, 123-130]. Тэгээд 1779 онд эцгийн засаг төрийн жүн ван хэргэмийг залгамжилж, төрийн эфү болсон Юндэндорж 1783 онд Түшээт хан аймгийн туслагч жанжин, Хүрээний хэрэг шийтгэгч сайдаар томилогдож, 1827 оны 11 сард нас барах хүртлээ уг тушаалыг хашсан билээ [Бао 1994, 514-515]. Дээр дурдсанчлан тус сурвалжийг 1827 оноос өмнө буюу Юндэндоржийн нас барахаас өмнө зохиогдсон хэмээсэн учир ийм болно.

Хүрээний сайд Юндэндорж нь улс төрийн зүтгэлтэн байгаад зогссонгүй Монголын эрдэм соёлыг дэлгэрүүлэхэд багагүй хувь нэмэр оруулсны нэг гэрч нь, хуучин цагийн монголчуудын дунд ихэд тархсан *tongyol-un jayun üsüg orusibai* хэмээх монгол үсгийн цагаан толгойг зохиосон явдал болно. Нийт монголчуудын дунд барламал, гар бичмэл хуулбараар ихэд өргөн дэлгэр тархсан энэхүү цагаан толгойг Тэнгэрийн тэтгэсэний 54-р (1789) онд Халхын Хүрээний сэцэн далай шанзодба Дамчойравжаа дуртгаснаар Хүрээний сайд ван Юндэндорж зохиосон боловч энэхүү цагаан толгой нь нийтэд Дамчойравжаагийн цагаан толгой хэмээн алдаршчээ. Үүний учир нь, уг цагаан толгойг анх Хүрээнд барлахад ямар нэг шалтгаанаар зохиогч Юндэндоржийг дурдсангүй ганцхан шанзодба Дамчойравжаа хэвд сийлүүлэв хэмээсэн байх бөгөөд мөн тэр оны эцсээр дахин бар сийлүүлж, Юндэндорж ванг зохиогч

хэмээн нэмж оруулсан³ боловч өмнөх бараас илүү урт төгсгөлийн үгтэй болсноос тэр үү, дэлгэрлийг олж чадсангүй [Отгонбаатар, Цендина 2014, 23-24] энэхүү цагаан толгой нь зохиогчийнхоо нэрээр бус харин бард сийлүүлсэн өглөгийн эзнийхээ нэрээр алдаршсан ажээ.



Сурвалжийн агуулга, шинж чанар

Нэгэнт дурдсанчлан, тус сурвалж манж, хятад хоёр хэлээрх бичвэрээс бүтнэ. Үүнд, манж бичвэрт, түшмэлийн тоо, Хадгалсан данс хар, Сайд нарын хууль болгон мөрдөх хэрэг зүйл, тухайлбал сайдын харьяат Түшээт хан, Сэцэн хан хоёр чуулганы хошууны тоо, ноёдын хэргэм, хоёр аймгийн хариуцах өртөө, харуулын тоо, түүнийг захирах тайж түшмэд, санд хадгалсан мөнгө, түүнийг хэрхэн албанд хэрэглэх, түшмэдийн цалингийн хэмжээ, хэрхэн хаанаас авахуулах, сайд түшмэдийн уналга морь, Дээр айлтгах тогтмол хэргийг айлтгах, барих ангийн махыг явуулах тухай нэг бүрчлэн дурджээ. Түүний дараа

³ *ngri-yin tedkügseñ-ü tabin dörbedüger on šarayčün takiy-a jil-ün ebül-ün ekin sarayin buyan öljei büriddügsen šar-a luu edür erdeni sečen dalai šangjodba damčoyirabjai. degedü vačir dar-a blam-a-yin šabdan batudču qatuy amitan qotalayar amur boltuyai kemen čaylasi ügei buyan sedkil egüskejü mongyol-un jaγun üsüg ba erkim itegel. nom-i bičigüliü-e kemegsen-i jarliy-iyar jaruγsan küriyen-dür sayuju kereg sidkegči sidar-tur yabuqu qalq-a-yin jegün γar-un čerig-i jakiraqu tusalayči jangjun jasaγ-un törü-yin giγün vang. törü-yin epü yündündorji bi ber čing ünenkü süjüg-i sanaju. šajin-u nara boluγsan degedü vačir dara jibzundamba blam-a-yin ölmei lingqu-a ulam tungyalay batudču burqan-u sajin arban jüg-tür delgereged. qotala qatuy amitan čaylasi ügei amuyulang jirγalang-i edlejü qočurli ügei darui türgen-e degedü qutuy-yi olqu boltuyai kemen mongyol-un jaγun üsüg ba. megdzem nom-i bičijü. erdeni sečen dalai sangjodba damčoyirabjai seyilgeged süngbüm-yin-dür talbibai.:* [Отгонбаатар, Цендина 2014, 28]

сурвалжийн гуравны нэг орчим хувийг эзлэх нь Оростой харилцсан хэрэг буюу Орос зүгийн харуулыг хэзээ хэрхэн байгуулсан, улмаар харуулын газар гарсан томоохон хэрэг болох 1767 оны Улханы харуулын хэрэг, 1783 оны Улаалзайн хэргийн учир явдал, улмаар Хиагтын худалдааг удаа дараа хаасан, Эрхүү хотын губернаторын тухай мэдээлэл, 1727 онд Оростой тогтоосон Хиагтын гэрээний 11 зүйл, 1792 онд нэмсэн зүйл, мөн онд Хүрээний сайд нар Хиагтад одож Эрхүүгийн губернаторт сурган ухуулсан 5 зүйл хийгээд дээрх Хиагтын гэрээний 11 зүйлийн 10-р зүйлийг хасч тогтоосон тухай байна. Үргэлжлүүлэн, 1768 онд үр хүүхэдгүй бол хэрхэн хүний хүү тэжээх, өв хөрөнгийг хэрхэн өвлүүлэх тухай хоёр заалт, 1783 онд хоёр аймаг, шавь гурван газраас нийгэмчлэн ээлжлэн жасаа гаргах мөнгө, яамны ажилтаны цалин хүнс, Хүрээний өмнө этгээдийн 14, Хиагт хүртэл тавьсан халхын 11 өртөө, Орос зүг тавьсан 46 харуулын нэр, харуулын цэрэг, зангийн тоо, 1759 болон 1786 онд харуулын дотуур сэрэмжлэн цэрэг цагдаа суулгасан, 1772 онд Орост оргосон 32 хүнийг эгүүлэн авсан, 1771 онд торгууд нар Оросоос ирсэнийг товч дурджээ. Түүний дараа, Орос, Прусс, Франц зэрэг өрнөдийн оронд холбогдох товч мэдээлэл дурдсаны эцэст, зохиогч өөрийн хошууны эр төөлсөн дансыг хавсаргажээ. Үүнтэй харьцуулахад, хятад бичвэр нь хэмжээ, агуулгын хувьд төсөр хураангуй бөгөөд яамны түшмэлийн орон тоо, Хадгалсан ном зүйл, уулын тахилга болон сайдын газар хэрэглэх унаа морь, Тогтмол айлтгах хэрэг, хоёр аймгийн хошууны тоо, ноёдын хэргэм, Тогтсон хугацаанд шалгах байцаах хэргийг зүйл дараалан дурдсан нь агуулгын хувьд манж бичвэртэй давхцаж байна. Өөрөөр хэлбэл, хятад бичвэрт Оростой харилцсан хэрэг явдал, харуул, өртөөний тухай огт дурдаагүйн дээр эр төөлсөн данс мөн байхгүй байна.

Эндээс үзвэл, тус сурвалжийн гол агуулга нь Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын эрхлэн шийтгэх үүрэгт ажил болох Хиагтын хоёр газар, Хан уул, Хэрлэн барс хотын хоёр чуулган, Жавзандамба хутагтын шавь нар, Халхын дөрвөн аймгийн гэр харуул, Хүрээний өмнө хойно байх хоёр замын өртөө хийгээд Оростой хэлэлцэж тогтоосон хэргийг нэг бүрчлэн тоочин жагсаасан байна. Харин Юндэндоржийн хошууны эр төөлсөн данс нь сурвалжийн агуулгад шууд холбоогүй, зохиогч ташрамд хавсаргасан бололтой. Тиймээс тус сурвалжийн агуулга нь Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын ажил үүрэг, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах, мэдвэл зохих хэрэг зүйл байна.

Үүнд, тус сурвалжийн хятад нэр, ерөнхий бүтэц нь “Ховдын хэргийн зүй”, “Илийн хэргийн зүй”, “Өрөмчийн хэргийн зүй”, “Тарвагатайн

хэргийн зүй”, “Улиастайн товч тэмдэглэл”, “Хөлөнбуйрын газрын ерөнхий хууль” гэх мэт Манж Чин улсын орон нутагт суух жанжин, сайд нарын тухайн газар шийтгэн явуулах хэргийг хураан бичсэн зохиолтой адил байгаа нь санамсаргүй тохиолдол бус буй за. Тэдгээр зохиолыг бичих болсон шалтгааныг “Ховдын хэргийн зүй”-н жишээгээр үзвээс дараах мэт. 1796 онд Цэргийн яамны жигүүрийн сайдаас Ховдод хуувийн сайдаар томилогдсон Фүжүн, Ховдод ирээд ямар хэргийг хэрхэн шийтгэхийг үл мэдэх тул олон түшмэл, монголчууд, худалдааны иргэд гэх мэт холбогдох этгээдээс лавлан асууж, олон жилийн данс бичгийг эргүүлэн үзсэний эцэст, “сая элдэв хэргийн уг үндсийг нэг бүрчлэн олж мэдэв” хэмээсэнчлэн, Манж Чин улсыг төлөөлөн олон угсаатны оршин суух газар орныг захиран суухад, шинэ томилогдсон сайд түшмэд тухайн албан тушаалын эрх, үүрэг, тухайлбал ямар хэргийг хэрхэн эрхлэн шийтгэхийг мэдэж авахад тодорхой хугацаа шаардагдаж байв. Хожим Ховдоос Кашгарт шилжин суусан Фүжүн тэнд, “Шинэ хязгаарын хэргийн зүй” хэмээх нэгэн дэвтрийг олж үзвээс, их хэлхээ нарийн нягт, анги зүйл ялган салгасан бөгөөд дутуу зүйл үгүй. Түүнд зүйлийн гарчиг болбаас Ховдын хэрэгт адилтгах нь нэгэн дундуур тул тэрхүү тэмдэглэснийг үлгэр болгож”, “Ховдын засгийн хэргийн бүгд цэс”-ийг хураан бичээд, Ховдод илгээжээ. Тийнхүү албан хэрэг шийтгэхэд туслах, гарын авлага болгох зорилгоор хураан бичсэн зохиолоо Фүжүн Ховдод илгээж, дараа дараагийн сайд түшмэлд, “тушаалын хугацаанд шийтгэсэн хэрэг зүйлийг нэг нэгээр зохион оруулж, нэмэн бичихийг” захисны үр дүнд “Ховдын хэргийн зүй” хэмээх сурвалж бүтжээ [Оюунжаргал 2004, 1-20]. Энэ мэт Манжийн төрийг төлөөлж орон нутагт суух жанжин, сайд нарт гарын авлага болгох зорилгоор XVIII зууны сүүлийн хагасаас XIX зууны дунд үе хүртэлх хугацаанд зохиогдсон дээрх мэт сурвалжуудтай, тус “Хүрээний хэргийн зүй” адил шинж чанартай байна. Өөрөөр хэлбэл, Юндэндорж тэдгээр сурвалжийн талаар зохих хэмжээний мэдлэг мэдээлэлтэй байсан, тэдгээрийг дууриаж Хүрээний хэргийг хураан бичсэн болохыг харуулж байна. Гэхдээ дээр дурдсан сурвалжуудтай харьцуулахад, “Хүрээний хэргийн зүй” нь оршил буюу хэн хэзээ бичсэн тухай тодорхой тайлбаргүй, тусгайлан гарчиг өгч, зүйл ангилан хуваагаагүй зэрэг харьцангуй задгай бичлэг бүхийг дурдвал зохино. Энэ нь Хүрээний сайдын эрхлэн шийтгэх хэргийг анх удаа нэгтгэн бичсэн хувилбар буюу дээр дурдсан Фүжүний зохиол мэт хожмын сайд түшмэд үзэж, хянан сайжруулж, нэмж засаагүй болохыг илэрхийлэх мэт. Сурвалжид

хавсаргасан эр төөлсөн дансны огноо нь 1807, манж бичвэрийн төгсгөл дэх он 1820, сурвалжид дурдсан сүүлийн он 1823 гэдгээс үзэхэд, зохиогч Юндэндорж өөрөө болон эцэг нь олон жил Хүрээний сайдын алба хашсан, зохих сурвалж хэрэглэгдэхүүн түүний гарын дор байсан авч, тус сурвалжийг хураан бичихэд олон жил зарцуулжээ.

Сурвалжийн агуулгын үнэн бодит байдлын тухайд, нэг бүрчлэн бусад сурвалжийн мэдээтэй харьцуулан үзсэний дараа сая дүгнэвээс зохих авч, зохиогчийн тухайн албан тушаалыг хашсан он жил буюу шаардагдах мэдлэг мэдээлэлийг харгалзан үзвээс ерөнхийд нь итгэж болох мэт. Манай Үндэсний Төв Архивийн Манжийн үеийн сан хөмрөгт томоохон байр суурь эзлэх М1: Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яамны арвин баялаг монгол, манж данс хийгээд сүүлийн үед олноор хэвлэгдэж буй БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архивийн манж баримтын эмхэтгэл, тэдгээрийг ашигласан судалгаанд тулгуурлан, сурвалжийн агуулгыг хянаж үзэх, харьцуулах бүрэн боломж буй. Ер тус сурвалжийг ашиглахад, сурвалжийн үндсэн шинж чанар болох албан хэрэгт тус болохыг бодож, хураан бичсэн онцлогийг харгалзан үзвэл зохино. Юу хэмээвээс, аливаа албан тушаалын эрх мэдэл, гүйцэтгэх үүрэг нь тодорхой хугацаанд бүрэлдэж буй болдог атал тэрхүү үйл явцыг нэг дор хураан бичвэл анхнаасаа тийм байсан мэт сэтгэгдэл төрүүлэх сул талтай. Тухайлбал, Хүрээний сайдын үндсэн ажил үүрэг нь Халхын зүүн хоёр аймаг, Жавзандамба хутагтын шавь, Хүрээний өмнө, хойно хоёр замын өртөө, Орос зүг тавьсан харуулыг захирах гэдгийг бид хэдийн мэдэх авч чингэж эрх мэдлийг төвлөрүүлэхэд Хүрээнд сайд сууснаас хойш тодорхой цаг хугацаа, улс төрийн нөхцөл байдал шууд нөлөөлсөн билээ.

Тухайлбал, Хүрээний анхны сайд гэгдэх Санжайдоржийн хувьд, түүнийг туслагч жанжны хувиар Хүрээнд суулгасан бөгөөд түүнээс өмнө Хүрээний хэрэг болон Оростой харилцах хэргийг Түшээт хан Ямпилдорж хариуцаж байв. Хожим Оростой нууц худалдаа хийсэн хэргээр Санжайдоржийг огцруулж, Өвөрмонголын Харчин зүүн хошууны засгийн хошууны бэйс бөгөөд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны илүү жигүүрийн сайд агсан Хутурингааг Хүрээнд явуулж, түүнийг үүргийг түр хамааруулсан ба тэрбээр Санжайдоржийн оронд ажиллахдаа түүний туслагч жанжны тушаалыг орлож буй хэмээн ойлгож байв. Тиймээс Санжайдоржийн шийтгэж байсан Түшээт хан аймгийн туслагч жанжны шийтгэх хэрэг болох Оросын хэрэг болон Жавзандамба хутагтын Их шавийн хэргийг, Санжайдоржийн оронд туслагч жанжин

болсон, Түшээт хан Цэдэндоржид ажлаа хүлээлгэж өгөөд буцах санаатай байв. Харин Тэнгэрийн тэтгэсэн хааны санаа огт өөр, Санжайдоржид тусгайлан итгэл хүлээлгэж Хүрээнд хэрэг шийтгүүлсэнээс бус, туслагч жанжны хувьд дээрх хэргийг шийтгүүлсэн бус байжээ. Угтаа Жавзандамба болон Их шавь бол Түшээт ханы мэдлийн хэрэг байв. Санжайдорж тус аймгийн томоохон засаг ноёны хувьд Түшээт ханы оронд энэ ажилд томилогдсон хэрэг бөгөөд Түшээт ханы эрхийг Манжид үнэнч ноён Санжайдоржид шилжүүлэхийг зорьсон хэрэг байжээ. Түүний үр дүнд, Их Хүрээн дэх Жавзандамба хутагт болон Түшээт ханы эрх хүчийг бууруулахад Санжайдорж гол үүрэг гүйцэтгэсэн билээ [Ока 1992, 197-214]. Энэ мэт Тэнгэрийн тэтгэсэн хаан Монголын ван гүнгүүдээр Монголыг захируулах Чингийн үндсэн төрийн зарчмыг тууштай баримталж, Халх дахь ноёрхолоо бататган чангатгахдаа өөртөө үнэнч Санжайдоржийг ашигласан аж. Өөрөөр хэлбэл, Тэнгэрийн тэтгэсэн хаан Санжайдоржийн хамт хэрэг шийтгүүлэхээр Хүрээнд илгээсэн Номхон, Фүдэ, Чүда мэтийн манж түшмэдэд Халхыг захирах жинхэнэ эрх олгохыг хүссэнгүй бөгөөд тэднийг Халхын хэрэгт хэт оролцохыг хориглож байжээ. Хожим Санжайдорж Оростой нууц худалдаа хийсэн хэргээр нэгэн удаа ялагдал хүлээсэн атал, Хааны дэмжлэгийг алдсангүй учир нь чухам үүнд байжээ [Ока 2018, 223-240].

Тийнхүү Тэнгэрийн тэтгэсэн хааны Халхыг захирах бодлогыг хэрэгжүүлэх үүднээс Хүрээнд суух болсон Санжайдоржид аажмаар Хүрээний эрх мэдэл төвлөрч эхэлсэн ба манж сайдын хувьд, улмаар Түшээт хан Цэдэндорж тэргүүтэй монгол ноёд 1762 онд Санжайдоржид туслуулахаар сайд Номхоныг Хүрээнд ирүүлснээр Хүрээнд “сайд” сууж эхэлсэн хэмээн ойлгож байв. Гэхдээ Хүрээний сайд тамгатай болсон нь 1767 оны 11 сараас болно. Юу гэвэл, 1765-1767 онд Санжайдоржийн Оростой нууц худалдаа хийсэн хэргийг шалгахад ирсэн зарлигаар зарсан сайд Хутүрингаа хүрээнд тэргүүлэн хэрэг шийтгэх болсон ч тэр бээр туслагч жанжин Цэдэндоржийн тамгаар хэрэг шийтгэж байсан бөгөөд 1767 онд Улханы харуулын хэргийн улмаас тусгайлан захирлага хэрэглэх болжээ. Гэхдээ Хүрээн дэх сайд нь Халхын туслагч жанжин, Түшээт хан, Түшээт хан аймгийн чуулганы даргатай ээлжлэн аль нэг нь тэргүүлэн хэрэг шийтгэж байв. Энэ үеэс Хүрээнд тэргүүлэн хэрэг шийтгэх, туслан хэрэг шийтгэх, сурч хэрэг шийтгэх гэсэн ялгавартай сайдын орон бий болжээ. Түүнээс хойш 1802 он болтол Хүрээний сайд нар Түшээт хан аймгийн туслагч жанжин, Түшээт хан аймгийн чуулганы даргын тамгыг “Зарлигаар зарсан сайдын захирлага”-тай хослуулан

хэрэглэж байсан нь Хүрээнд сайдын газар байгаагүй, сайд байсантай холбоотой юм. Үүнд, 1780 он сайдын газар нь тодорхой мөнгөн сан үгүй, албан хэрэглэлийг ихэвчлэн Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас гаргаж байсан бөгөөд яваандаа Оростой худалдаалах худалдаачид болон хууль зөрчсөн засгуудыг торгох, эд хөрөнгийг хураах зэрэг бие даасан эх үүсвэртэй болж, 1800 онд сая Хүрээний яамны албан байртай болж, 1802 онд манж, монгол, хятад гурван үсгээр бичсэн “Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд”-ын тамга хэрэглэх болсон зэргийг дурдаж болно [Одбаяр 2011].

Ийнхүү Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газар нь Санжайдоржийн үеэс үндэс суурь нь тавигдсан боловч чухам Юндэндоржийн үед хэлбэржин тогтож, Манж Чин улсын гадаад харилцааны хэрэгт ч их нөлөөтэй оролцдог ихээхэн чухал газар болон хувирсан билээ. Үүнд, Хүрээний сайд Юндэндоржийн зохиосон “Хүрээний хэргийн зүй” хэмээх сурвалжийн гол ач холбогдол нь Манжийн үеийн Хүрээ нь Халхын улс төр, шашны төв болон хувирч хөгжсөн түүхийг өгүүлсэнд оршино.

Ном зүй

- Bao 1994: *Bao Guiqin*. Qingdai menggu guanli chuan. Үндэсний хэвлэлийн хороо, Beijing, 1994. (Бао Гуйчин. “Чингийн үеийн монгол түшмэдийн шастир”)
- Jin Tingshi 2017: 金珽実『満州 間島における日本人一満州事変以前の日本語教育と関連して』, 花書院, 2017. (Жин Тинши. Манжуур-Кантоо дахь япончууд: Манжуурын хэрэг явдлаас өмнөх япон хэлний сургалтын тухай)
- Отгонбаатар, Цендина 2014: *Р.Отгонбаатар, А.Д.Цендина*. Образцы письменной традиции Северной Монголии. Москва, Наука – Восточная литература. 2014.
- Одбаяр 2011: *Г.Одбаяр*. “Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газар”-ын тухай зарим асуудлууд. Магистрын зэрэг горилсон дипломын ажил. МУИС, НШУС. Түүхийн тэнхим, УБ, 2011.
- Ока 1992: *Oka Hiroki*. Kūron Benji daijin ni kansuru ichi kousatu, Kanda Nobuo Sensei Koki Kinen Ronshū. Shinchou to Higashi Ajia, Токио, 1992, 197-214. (Ока Хироки. Хүрээний хэрэг шийтгэгч сайдын тухай судалгаа)
- Ока 2018: Ока Хироки. Цэнгүнжав ба Санзайдорж, Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа, Эмхэтгэн хэвлүүлсэн Т.Баясгалан, Ч.Батдорж, Улаанбаатар, 2018, 223-240.
- Оюунжаргал 2004: *О.Оюунжаргал*. “Манж Чин улсын үеийн Ховдын хязгаарт холбогдох нэгэн сурвалжийн тухай, Northeast Asian Study Series 7,

- Монголын түүх, угсаатны судлалын зарим асуудалд, Center for Northeast Asian Studies, Tohoku University 2004,1-20.
- Uehara 1966, 1967: 上原久「渡部薫太郎の満洲語学1, 2」Journal of Saitama University, Cultural science (14), 1-17, 1966-03, Cultural science (15) 1-60, 1967. (Үэхара Хисаши. Ватанабэ Шигэтароо-гийн манж хэл судлал 1, 2)
- Watanabe 1932: *Watanabe Shigetarō*, *Manshū-go tosho-mokuroku*, (zōteiban), *Ajia kenkyū, dai3-gō*, Ōsaka Tōyō gakkai, *Mishima Kaibundō*, 1932. (Шигэтароо Ватанабэ: Манж хэлээрх номын бүртгэл)
- Wulanbagen 2016: *Wulanbagen*. *Zhu kulun banshi kaerka fu jiangjun sangzhaiduoerji kaolun*, Мануу уянжиу, *Manchu Studies*, №1, 2016 (General №62), 123-130. (Улаанбагана. Хүрээнд сууж хэрэг шийтгэх Халхын туслах жанжин Санжайдоржийн тухай).